

**ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ****(Иргэний эрх зүйн маргаан¹)****КРЕДИТ КАРТЫН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД “ЭРХ ХЭТРҮҮЛСНИЙ
ХҮҮ, ХУГАЦАА ХЭТРҮҮЛСНИЙ НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮ” ЗЭРЭГ ХУУЛЬД
ЗААГААГҮЙ ХҮҮ ТООЦОХ НЬ ҮНДЭСЛЭЛГҮЙ**

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/00084

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч “Г” ХК нь хариуцагч Н-аас кредит картын зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд нийт 17.669.568,94 төгрөг гаргуулах тухай шаардлага гаргаж, үндэслэлээ: “...Н нь “Г” ХК-тай 2018.02.21-ний өдөр 5.000.000 төгрөгийн зээлийн эрхтэй кредит картын гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан ба бэлэн бус гүйлгээний сарын хүү 2 хувь, бэлэн гүйлгээний сарын хүү 3.5 хувь, зээлийн эрх хэтрүүлсэн нэмэгдүүлсэн хүү 2 хувь, зээлийн хугацаа хэтрүүлсний нэмэгдүүлсэн хүү 1 хувь байхаар тохиролцсон. Н нь кредит картаас нийт 4.990.044,65 төгрөгийн бэлэн болон бэлэн бус зарлагын гүйлгээ хийсэн. 2018.02.12-2024.05.22-ны өдрийг хүртэл хугацааны үндсэн зээлийн үлдэгдэл 4.990.044,65 төгрөг, хүү 5.963.865,38 төгрөг, хугацаа хэтрүүлсний хүү 5.166.995,11 төгрөг, эрх хэтрүүлсний хүү 548.663,80 төгрөг, нийт 17.669.568,94 төгрөг гаргуулна гэж тайлбарласан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шаардлагын хэмжээг 12.146.683,11 төгрөг болгон багасгажээ.

Хариуцагч тайлбартаа: “...Нийт 5.000.000 төгрөгөөр зээлжих эрхтэй гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан. 4 өөр хүү бодож гэрээ байгуулсныг хууль зөрчсөн

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/10806?daterange=2025-01-01%20-%202025-10-13&id=3&court_cat=1&bb=1



гэж үзэж байна. Иргэний хууль (цаашид “ИХ” гэх)-ийн 56 дугаар зүйлийн 56.1², 56.5³ дахь хэсэгт заасан үндэслэл бий болсон. Иймд нэмэгдүүлсэн хүү, хугацаа хэтрүүлсний хүүг шаардах эрхгүй. Мөн гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан ба хугацаа нь 2020.02.21-ний өдөр дууссан. Гэтэл нэхэмжлэлийг 2024.06.25-ны өдөр гаргасан тул ИХ-ийн 75 дугаар зүйлийн 75.2.1⁴ дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох үндэслэл тогтоогдож байна” гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүх:** Хариуцагч нь 5.000.000 төгрөгийн зээлийн эрхтэй кредит картын зээлийн гэрээг 2 жилийн хугацаатай байгуулж, уг картаас бэлнээр төлөх тохиолдолд сарын 3.5 хувь, бэлэн бусаар төлөхөд сарын 2 хувийн хүүг ашигласан зээлийн хэмжээнээс тус тус тооцож төлөх үүргийг хүлээсэн. Харин гэрээнд “зээлийн эрх хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү 2 хувь, зээлийн хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү 1 хувь” гэж, “зээлийн эрхийн хэмжээг хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд хэтрүүлсэн дүнд зээлийн эрх хэтрүүлсний нэмэгдүүлсэн хүүг сарын 2 хувиар тооцно” гэж, “Төлбөр эргэн төлөх өдрөөс өмнө эргэн төлөх доод хэмжээг төлөөгүй бол эргэн төлөх доод хэмжээнээс хугацаа хэтрүүлсний нэмэгдүүлсэн хүү сарын 1 хувиар тооцно” гэж тус тус заасныг ИХ, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (цаашид “БЭБХЭМХМХШЗҮАТХ” гэх)-д тус тус заагаагүй хүү авахаар тохиролцсон гэж дүгнэж, үндсэн зээл 4.990.044,65 төгрөг, үндсэн хүү 5.963.865,38 төгрөгийг хариуцагчаас гаргуулж, нэмэгдүүлсэн хүүг хэрэгсэхгүй болгосон байна. Түүнчлэн давж заалдах шатны шүүхийн 2023.04.27-ны өдрийн 203/МА2023/00015 магадлалыг үндэслэн нэхэмжлэгчийн шаардах эрх хэрэгжүүлэх хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй, хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан үйл баримт тогтоогдож байна гэж дүгнэжээ.
2. **Давж заалдах шатны шүүх:** Хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан үйл баримт тогтоогдсон тухай анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй. Хариуцагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тул нэхэмжлэгч зээлийн үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүүг шаардах эрхтэй. Харин нэхэмжлэлд дурдсан зээлийн гэрээнд тусгайлан заасан хүүнүүдийн талаарх нэр томьёог холбогдох хуулиудад тодорхойлсон тодорхойлолтууд тусгагдаагүй, нэхэмжлэгч нь үндсэн зээлийн гүйцэтгээгүй үүргийг хэдий хугацаанд хэдэн төгрөгөөс хэрхэн яаж тооцож тогтоосон талаарх хуульд заасан шаардлагыг хангасан нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөөгүй тул хууль тогтоомжид заагаагүй дээрх

² Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1. “Дараахь хэлцэл хүчин төгөлдөр бус байна:”

³ ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.5. “Энэ хуулийн 56.1-д заасан хэлцэл хийсэн талууд нь уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.”

⁴ ИХ-ийн 75 дугаар зүйлийн 75.2.1. “гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил”



хүүнүүдийг хариуцагчаас гаргуулах хууль зүйн үндэслэлгүй. Мөн зээлийн гэрээний 2 жилийн хугацаанд хариуцагчийн ашигласан зээлээс зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг тус тус тооцох нь зүйтэй гэж дүгнээд, үндсэн төлбөр 4.990.044,65 төгрөгийн 2 хувь 99.800 төгрөг /сард төлбөл зохих хүү/-ийг 24 сараар тооцон үндсэн хүү 2.395.221 төгрөг, нэмэгдүүлсэн хүү 479.040 төгрөг, нийт 7.880.305 төгрөгийг хариуцагчаас гаргуулж, үлдэх 4.264.378,11 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон өөрчлөлтийг анхан шатны шүүхийн шийдвэрт оруулжээ.

- 3. Нэхэмжлэгчээс гаргасан хяналтын гомдлын агуулга:** Давж заалдах шатны шүүхээс дээрх хуулиудыг зөв хэрэглэж, нэхэмжлэгчийг шаардах эрхтэй талаар дүгнэсэн боловч хариуцагчийг зээлийн гэрээний хугацаа буюу зөвхөн 2 жилийн хугацаанд зээлийг ашигласан гэж үзэж үндсэн зээлээс зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг тус тус тооцсон нь үндэслэлгүй буюу хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэж байна. Мөн ИХ-ийн 189 дүгээр зүйлийн 189.1⁵-д заасны дагуу талууд гэрээний агуулгыг өөрсдөө тодорхойлсон. Бэлэн болон бэлэн бус гүйлгээний хүүг үндсэн хүү, хугацаа хэтрүүлсэн болон эрх хэтрүүлсний хүүг нэмэгдүүлсэн хүү гэж үзэн гэрээний ерөнхий нөхцөлд тусгасан. Мөн хэргийн материалд кредит картын тооцооллын хүснэгт авагдсан бөгөөд гэрээ байгуулснаас хойш шүүхэд нэхэмжлэл гаргах хүртэлх хугацаанд хүү, нэмэгдүүлсэн хүүг хэрхэн тооцож гаргасан нь харагдаж байна. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж өгнө үү гэжээ.
- 4. Хяналтын шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ:** Анхан шатны шүүх зээл, үндсэн хүүг тооцохдоо зээлийн үлдэгдэл 4.990.044,65 төгрөгийг 2019.01.19-2024.05.22-ны өдрийг хүртэл уг зээлийг ашигласан гэж үзэн, зээл 4.990.044,65 төгрөг, үндсэн хүү 5.963.865,38 төгрөгийг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн нь БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2⁶ дахь хэсэгт заасан зохицуулалтад нийцсэн, шүүх хэргийн баримтыг хуульд зааснаар үнэлэх журмыг зөрчөөгүй байна. (14.1)⁷
- 5.** Давж заалдах шатны шүүх зээлийг ашигласан бүх хугацаагаар бус зөвхөн картын гэрээний үндсэн хугацаа болох 2 жилээр үндсэн хүүг тооцож багасган анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахдаа БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасныг буруу хэрэглэсэн, улмаар мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3⁸-т заасныг зөрчсөн байх тул нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангана. (14.2)

⁵ ИХ-ийн 189 дүгээр зүйлийн 189.1. “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.”

⁶ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. “Зээлийн хүүг зээлийг ашигласан хугацаагаар тооцно.”

⁷ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁸ БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.3. “Зээлийн гэрээний хугацаа дууссан нь тухайн гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.”



6. Хэргийн баримтаас үзэхэд нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгож буй зээлийн гэрээнд хэд хэдэн, өөр өөр нэршилтэй, ялгаатай хувь хэмжээ, хугацаа тогтоосон “нэмэгдүүлсэн хүү”-г тооцохоор заасан байх тул нэхэмжлэгч “Г” ХК-ийн хариуцагч Н-аас нэмэгдүүлсэн хүү гэж шаардсан 1.192.773,08 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1⁹, 40.2¹⁰-т заасныг зөрчөөгүй, шийдвэр ИХ-ийн 452 дугаар зүйлийн 452.2¹¹-т нийцсэн байна. (14.3)
7. БЭБХЭМХМХШЗҮАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.3¹²-т заасны дагуу батлагдсан аргачлалд кредит картын зээлийн гэрээнд хэрэглэх “хүү”-гийн талаар тусгайлан заагаагүй байна. Харин зээлийн үндсэн хүү болон нэмэгдүүлсэн хүүг хэрхэн тооцоолохыг уг аргачлалд нарийвчлан тайлбарласан байна. Иймээс нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан “...хууль тогтоомжид заагаагүй хүүнүүдийг хариуцагчаас гаргуулах үндэслэлгүй гэж үзсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч, кредит карт эзэмшигчтэй байгуулах гэрээ нь гэрээний агуулгыг өөрсдөө тодорхойлсон гэрээ юм” гэсэн гомдлын энэ хэсгийг хангахгүй. (17)
8. Давж заалдах шатны шүүх ИХ болон БЭБХЭМХМХШЗҮАТХ-ийг буруу тайлбарлан хэрэглэж, кредит картын зээлийн гэрээний 2 жилийн хугацаагаар зээлийн хүү нэмэгдүүлсэн хүүг тус тус тооцсон нь хуульд нийцээгүй тул магадлалыг хүчингүй болгоно. Анхан шатны шүүх хариуцагчаас үндсэн зээл, үндсэн хүүг гаргуулж, харин нэмэгдүүлсэн хүүг хэрэгсэхгүй болгохдоо хэргийн баримтыг хуульд зааснаар үнэлсэн, ИХ-ийн 452 дугаар зүйлийн 452.2-т заасныг зөв хэрэглэсэн байх тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гаргасан гомдлын зарим хэсгийг хангах нь зүйтэй хэмээн дүгнэжээ.

---ооо--

⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1. “Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.”

¹⁰ ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2. “Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ”

¹¹ ИХ-ийн 452 дугаар зүйлийн 452.2. “Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.”

¹² БЭБХЭМХМХШЗҮАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.3. “Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.”